



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЗГААР
0 дугаар 02 дүгээр хэсэг 05
№05 /62в

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

174

**Хүний хөгжил сангаас Монгол
Улсын иргэнд 2010 онд хүртээх
хишиг, хувийн хэмжээг тогтоох
тухай**

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

175

**Иргэний шинэчилсэн бүртгэл
явуулах тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

182

**Хэмжлийн нэгдмэл байдлыг
хангах хөтөлбөр батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|-----|
| 52. | Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай | Дугаар 99 | 174 |
| 53. | Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай | Дугаар 100 | 175 |
| 54. | Түр хороо байгуулах тухай | Дугаар 01 | 175 |
| 55. | Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 02 | 177 |
| 56. | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 03 | 179 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|--|------------|-----|
| 57. | Монгол Улсын Гавьяат цол хүртээх тухай | Дугаар 168 | 180 |
| 58. | Доржийн Эрдэнэчулуунд Гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 172 | 182 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|-----|
| 59. | Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөр батлах тухай | Дугаар 346 | 182 |
|-----|---|------------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2009 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот**Хүний хөгжил сангаас Монгол Улсын
иргэнд 2010 онд хүртээх хишиг,
хувийн хэмжээг тогтоох тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд 2010 онд Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийн хэмжээг 120,0 мянган /нэг зуун хорин мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2.Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хүний хөгжил сангийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх;

2/шинээр Монгол Улсын харьяат болсон иргэний тухайн жилд ногдох хишиг, хувийг харьяат болсны дараа жилээс эхлэн олгох;

3/Монгол Улсын иргэн тус улсын харьяатаас гарч гадаад улсын харьяат болох хүсэлт гаргавал харьяатаас гарах жилийн олгох мөнгөний хэмжээгээр бодож 3 жилийн хишиг, хувийг 1 удаа олгох;

4/Монгол Улсын иргэнд хүртээх хишиг, хувийг 2 хувааж олгох бөгөөд эхний ээлжинд 70.0 мянган /далан мянган/ төгрөгийг 2010 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож, цаашид Монгол Улсын иргэнд хүртээх хишиг, хувийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1 Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэлийг 2010 оны 10 дугаар сард багтаан явуулах, үүнтэй холбогдуулан иргэний ухаалаг үнэмлэх олгох суурь дэд бүтэц, иргэний биеийн өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан бий болгох, иргэнд хишиг, хувь хүртээх үйл ажиллагааг иргэний шинэчилсэн бүртгэлтэй уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2/дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах ажиллагааг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 6,755.0 сая /зургаан тэрбум долоон зуун тавин таван сая/ төгрөгт багтаан гүйцэтгүүлэх;

3/өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлсэн иргэний шинэчилсэн бүртгэл явуулах үйл ажиллагааны санхүүжилтийг бүртгэл дууссан хугацаанаас эхлэн улсын төсөвт тусган санхүүжүүлэх.

2 Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүний хөгжил сангаас иргэдэд нийгмийн халамж, үйлчилгээг бодитой, хүртээмжтэй хүргэх, "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг

хэрэгжүүлэх, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллолыг зохион байгуулахтай холбогдуулан бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний үр ашгийг тооцох, бодлогын хувьд нэгдмэл, цогц байдлаар авч үзэж, уялдаа холбоог хангах, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий Нэгдсэн бүртгэл, мэдээллийн түр хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|------------------|------------------------|
| 1.Б.Батбаяр | Улсын Их Хурлын гишүүн |
| 2. Н.Батбаяр | Улсын Их Хурлын гишүүн |
| 3.Ц.Батбаяр | Улсын Их Хурлын гишүүн |
| 4.С.Бямбацогт | Улсын Их Хурлын гишүүн |
| 5.Э.Мөнх-Очир | Улсын Их Хурлын гишүүн |
| 6.Д.Очирбат | Улсын Их Хурлын гишүүн |
| 7.Ч.Сайханбилэг | Улсын Их Хурлын гишүүн |
| 8.Ж.Сүхбаатар | Улсын Их Хурлын гишүүн |
| 9.Х.Тэмүүжин | Улсын Их Хурлын гишүүн |
| 10.Д.Тэрбишдагва | Улсын Их Хурлын гишүүн |
| 11. Д.Энхбат | Улсын Их Хурлын гишүүн |
| 12.З.Энхболд | Улсын Их Хурлын гишүүн |
| 13.Н.Энхболд | Улсын Их Хурлын гишүүн |

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан асуудалд дүн шинжилгээ хийх, шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж дуусган, ажлынхаа дүнг Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганд танилцуулахыг Нэгдсэн бүртгэл, мэдээллийн түр хороонд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолд дор дурдсан агуулгатай дараахь заалт, дэд заалт нэмсүгэй:

1/ 1 дэх заалтын 5 дахь дэд заалт:

"5/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, хууль сурталчлах болон бусад орны хууль тогтоомж, туршлагатай танилцах, судлахтай холбогдсон зардлыг тухайн оны төсөвт батлагдсан хэмжээгээр Улсын Их Хурлын гишүүний төсөвт хуваарилан, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга зарцуулна."

2/ 5 дахь заалт:

"5.Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслахын болон бие төлөөлөгч-туслахын албан тушаалын сарын цалинг тухайн оны төсөвт батлагдсан хэмжээгээр хуваарилан, төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ болон Улсын Их Хурлын гишүүдийн саналыг харгалзан Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно."

2. "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын, мөн тогтоолын 2 дахь заалтын "Байнгын хорооны даргад" гэсний дараа "болон намын бүлгийн ахлагчид" гэж тус тус нэмсүгэй.

3. "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох,

зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолын 5-7 дахь заалтын дугаарыг "6-8" болгон тус тус өөрчилсүгэй.

4."Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын "үйл ажиллагааныхаа талаар тойргийн сонгогчид, олон нийтад мэдээлэх, сурталчлах, зайлшгүй шаардлагатай бусад мэдээлэл цуглуулах, зарим" гэснийг хассугай.

5."Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам"-д дор дурдсан агуулгатай дараахь заалт, дэд заалт нэмсүгэй:

1/ Журмын 1.2.9 дэх дэд заалт:

"1.2.9.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, хууль сурталчлах, бусад орны хууль тогтоомж, туршлагатай танилцах, судлахтай холбогдсон зардал;"

2/ Журмын 3.10, 3.11 дэх заалт:

"3.10.Гишүүн энэ журмын 1.2.9-д заасан төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулах төсөв, төлөвлөгөөг боловсруулан санхүүжилтийг авах бөгөөд түүний гүйцэтгэлийн талаархи тайлан, тооцоог гарган, холбогдох баримтаар баталгаажуулж Тамгын газрын Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэстэй тухай бүр тооцоо хийнэ.

3.11.Гишүүн гадаад, дотоодод албан томилолтоор ажилласан хугацаанд хотын дотор хэрэглэх унааны зардлын хэмнэлтийг давхардуулж олгохгүй."

6."Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн

28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ын 1.2.7 дахь дэд заалтын "орон тооны туслахын зардал" гэснийг "зөвлөх, туслахын болон бие төлөөлөгч-туслахын зэрдал" гэж, мөн журмын 3.8.1, 3.8.2 дахь дэд заалтын "300" гэснийг "500" гэж, мөн журмын 1.2.9 дэх дэд заалтын дугаарыг "1.2.10", 3.10 дахь заалтын дугаарыг "3.12" болгон тус тус өөрчилсүгэй.

7. "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ын 1.4.8 дахь дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

8. Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 11 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар
хот

Монгол Улсын Гавъяат цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, эдийн засаг, байгаль орчин, нийтийн аж ахуй, хэвлэл мэдээлэл, урлаг, спортын салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажилласан доорх хүмүүст Монгол Улсын Гавъяат цолыг хүртээсүгэй.

ГАВЪЯАТ БАГШ ЦОЛ

1. Журьан Баянсан - МУИС-ийн багш, тэнхмийн эрхлэгч
2. Чойжилжавын Билигсайхан - МУИС-ийн МХСС-ийн багш, доктор профессор
3. Сангийн Баянжаргал - Өвөрхангай аймгийн Уянга сумын Ерөнхий боловсролын сургуулийн математикийн багш
4. Дамбийн Гоошоохүү - Эрдмийн ундраа цогцолборын багш
5. Уртнасангийн Давааням - Харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн багш
6. Жамбын Соронзон - Монгол - Оросын хамтарсан 3-р сургуулийн захирал

ХҮНИЙ ГАВЪЯАТ ЭМЧ ЦОЛ

1. Пэлжидийн Банзрагч - Дотор уламжлалт нөхөн сэргээх "Топуна" ХХК-ийн зөвлөх эмч
2. Балжиннямын Туяабадрах - Улсын клиникийн төв эмнэлгийн мэс засалч
3. Лувсандоржийн Эрдэнэбаяр - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал



ГАВЪЯАТ ДАСГАЛЖУУЛАГЧ ЦОЛ

1. Сандагийн Баясгалан - Боксын спортын Олон улсын шүүгч

ГАВЪЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ ЦОЛ

1. Даваадоржийн Ганболд - Нийслэлийн Засаг даргын орлогч

ГАВЪЯАТ ЖУЖИГЧИН

1. Жамсрангийн Сүххуяг - Баянзүрх дүүргийн иргэн, чөлөөт уран бүтээлч
2. Дэжидбалын Баянжаргал - Архангай аймгийн Хөгжимт жүжгийн театрын дуучин

УРЛАГИЙН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН

1. Бадарчийн Бямбабаяр - Хөгжмийн зохиолчдын холбооны дарга

СОЁЛЫН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН

1. Гомбожавын Очирбат - Сонин хэвлэлийн ахмад ажилтан, Хан-Уул дүүргийн өндөр настан

АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЪЯАТ АЖИЛТАН

1. Гарамхандын Базаргүр - УБЦТС ХК-ийн ТБЗХ-ийн дарга
2. Бат-Очирын Пүрэвжав - Ус сувгийн удирдах газрын дарга

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЪЯАТ АЖИЛТАН

1. Цэрэндашийн Дамдин - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөх

ГАВЪЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛ

1. Тарвагийн Сэрэээнэндагва - Барилгын "Монхангай" ХХК-ийн инженер

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар
хот

Доржийн Эрдэнэчулуунд Гавъяат барилгачин цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын авто замын салбарт 41 жил ажиллахдаа авто зам барих барилгын ажилд чухал шаардлагатай технологиудыг эзэмшин, замын барилгын гүйцэтгэлийг мэргэжлийн өндөр ур чадвартайгаар гүйцэтгэж, мэргэжлийн замчин болох залуу үед зааж сурган ажлын дадлага туршлагатай болоход мэргэжлийн зөвлөгч болсон "Эрдэнэ зам" ХК-ийн замчин Доржийн Эрдэнэчулуунд Монгол Улсын Гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 346

Улаанбаатар
хот

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хандивлагч орон, олон улсын бэйгууллагын буцалтгүй тусламжид хамруулах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2009 оны 346 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Эрүүл мэндийн салбарт хэрэглэж байгаа хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ихэнх нь хуучирч эвдрэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангаж чадахгүй болсон бөгөөд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнэн зөв ажиллагааг шаардлагын хэмжээнд явуулж чадахгүй байгаа зэрэг нь тухайн салбарт хэмжлийн нэгдмэл байдал алдагдахад хүргэж байна.

Сүүлийн жилүүдэд нэг зориулалтын хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж олон нэр төрөл, загварын гарал үүсэлтэй болж байгаа нь дээрх байдлыг улам хүндрүүлж, цаашид эрүүл мэндийн байгууллагыг найдвартай, чанартай хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, багаж, хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалт, шалгалт, тохируулгад бүрэн хамруулах нь оношилгоо, эмчилгээг сайжруулах, хүн амд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын түвшинг дээшлүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийг
хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн найдвартай, хэвийн, үнэн зөв ажиллагааг хангах, тэдгээрийг тогтоосон хугацаанд нь хяналт шалгалтад бүрэн хамруулах тогтолцоог бий болгох үндсэн дээр эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино;

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараахь зарчмыг



баримтална:

а) эдийн засаг, нийгэм, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэл, бодлогын баримт бичиг, үйл ажиллагаатай уялдан зохицсон байх;

б) хөтөлбөрийн хүрээнд шинээр баталсан эталоны нарийвчлал нь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, стандартын шаардлагад тохирсон байх;

в) иргэд, эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын тэгш оролцоог хангах.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн

Зорилт 1. Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийхэд шаардлагатай техникийн бааз суурийг бэхжүүлж бүрдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а) улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн батлах, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хоорондын хугацааны норм, нормативыг шинэчлэх;

б) эмнэлгийн оношилгоо, эмчилгээнд түгээмэл хэрэглэдэг хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийхэд шаардлагатай эталон, төхөөрөмжийг бий болгох;

в) эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх зориулалтын лабораторийг нээн ажиллуулах;

г) дээрх лабораторт ажиллах мэргэжилтнийг сургаж бэлтгэх;

д) эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг баталгаажуулах, шалгалт, тохируулгад хамруулах, тэдгээрт засвар, үйлчилгээ хийхэд шаардагдах стандарт, дүрэм, журам, зааврыг энэхүү хөтөлбөрийн дагуу боловсруулах.

Хүрэх үр дүн: Эмнэлгийн оношилгоо, эмчилгээнд түгээмэл хэрэглэдэг хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг баталгаажуулалт, шалгалт, тохируулгад хамруулахад шаардлагатай ажлын эталон, төхөөрөмж болон ажлын орчин бий болсон байна.

Зорилт 2. Эмнэлгийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх арга зүй, стандартыг боловсруулж, мөрдөх ажлыг зохион байгуулна. Энэ зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а) эрүүл мэндийн салбарт оношилгоо, эмчилгээний технологийг дээшлүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн чиглэлээр хэрэгжиж байгаа бусад төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулан үр ашгийг нь дээшлүүлэх;

б) тоног төхөөрөмжийн инженер, хэмжүүрийн улсын шалгагч болон шалгалт, тохируулгын ажилтанг мэргэшүүлэн бэлтгэх, эрдэм шинжилгээ,

судалгааны ажлыг оношилгоо, эмчилгээний үйл ажиллагаатай уялдуулах;
в) баталгаажуулалт, шалгалт, тохируулгатай холбоотой шалгах аргын стандарт боловсруулах ажлыг хөтөлбөрийн үе шаттай уялдуулан гүйцэтгэх;

г) эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн загварыг турших, батлах, хянах, мөрдөх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

д) улсын хэмжээнд ашиглаж байгаа болон цаашид ашиглах нэг ижил зориулалтын эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, чанар, эдэлгээ, засвар үйлчилгээ хийх боломж, хэмжил зүйн болон техник, стандартыг бүрэн тусгасан техникийн зохицуулалтыг хэрэглэж ажиллах.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хүний нөөцийн чадавхи бүрдэж эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалгаж тохируулах, баталгаажуулах арга зүй, стандарт бий болсон байна.

Зорилт 3. Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг улсын бүртгэл, баталгаажуулалт, шалгалт, тохируулгад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна. Энэ зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а) эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг улсын бүртгэлд авах;

б) оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүсчилсэн хэлбэрээр улсын баталгаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

в) эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэмжил зүйн хяналт шалгалтад хамруулах.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа болон цаашид ашиглах оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж нь улсын бүртгэл, баталгаажуулалт, шалгалт, тохируулга болон хэмжил зүйн хяналтад бүрэн хамрагдсан байна.

Зорилт 4. Эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн, үнэн зөв ажиллагааг тасралтгүй хангахад чиглэсэн засвар, үйлчилгээний ажлыг дэмжин хөгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а) аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх (угсрах), суурилуулах, засварлах, худалдах, шалгаж тохируулах үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, дэмжлэг үзүүлэх;

б) эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн загварыг турших, шалгах ажлын болон засварын

инженерийн мэргэшлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулах;

в) эмнэлгийн болон холбогдох байгууллагын төсвийн зардлын зүйл ангид хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, баталгаажуулалт, шалгалт, тохируулгатай холбоотой зардлыг тусгаж байх.

Хүрэх үр дүн: Эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн, алдаагүй ажиллагааг тасралтгүй хангах засвар үйлчилгээний мэргэшсэн аж ахуйн нэгж, байгууллага бий болж үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- а) улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- б) гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- в) олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- г) бусад эх үүсвэр.

4.2. Хөтөлбөрийг 2013 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг улсын хэмжээнд стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бусад холбогдох байгууллагын төлөөлөлтэй хамтран; орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

Хүн амын эрүүл мэндийн чиглэлээр:

-эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжирч, оношилгоо, эмчилгээний үр дүнг нарийвчилсан үзүүлэлтээр үнэн зөв гаргах боломж бүрдэнэ;

-магадлан итгэмжлэгдсэн эмнэлгүүдийн чадавхи сайжирна;

-эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, технологийн судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх боломж бүрдэнэ;

-эмнэлгийн техникийн ажилтнуудын мэдлэг, мэргэжил, үр чадвар дээшилнэ.

Хэмжил зүйн чиглэлээр:

-оношилгоо, эмчилгээнд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж нь улсын бүртгэл, баталгаажуулалт, шалгалт, тохируулгад бүрэн хамрагдаж, загварын туршилт, хяналтын асуудал нь зохих түвшинд шийдвэрлэгдэнэ;

-одоо ашиглаж байгаа болон импортоор орж ирж байгаа эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж нь улсын бүртгэлд хамрагдаж, хяналттай болно;

-гадаадын хандив, буцалтгүй тусламж, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын шугамаар орж ирэх эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт өгөх боломж бүрдэнэ;

-оношилгоо, эмчилгээний чадавхид тохирлын үнэлгээ хийх, аттестатчилах техникийн боломж бүрдэнэ;

-хэмжил зүй болон засвар үйлчилгээний талаархи эмнэлгийн инженер, техникийн ажилчдын мэдлэг дээшилж, судалгаа шинжилгээний ажилд ахиц гарна.

5.3. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээний тайланг гаргуулан авч нэгтгэнэ.

5.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга зэрэг нь дараахь түвшинд хүрнэ:

Үзүүлэлт		Одоогийн түвшин	Хүрэх түвшин		
		2009 он	2011 он	2012 он	2013 он
Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга	Аймаг, орон нутагт	8-10%	40%	60-70%	80% хүртэл
	Улаанбаатар хот	15-20%	40%	60-70%	80% хүртэл
Загварын туршилт, бүртгэл, хяналт	Аймаг, орон нутагт	-	30%	60%	100%
	Улаанбаатар хот	-	30%	60%	100%
Сургалт	Аймаг, орон нутагт	-	30%	60%	100%
	Улаанбаатар хот	-	30%	60%	100%

5.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн түвшин (2009 он)	Хүрэх үзүүлэлт (2013 он)
1	Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хоорондын хугацааны норм, нормативыг шинээр тогтоох	байхгүй	Хугацааны норм, норматив батлагдан мөрдөгдөнө
2	Хэмжих хэрэгслийн шалгах аргын олон улсын стандарт, норматив, техникийн баримт бичгийн шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн лабораторийг Улаанбаатар хотод Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэд болон бүсийн төв Ховд, Дархан, Чойбалсан, Эрдэнэт хотуудад шинээр байгуулан ажиллуулах	байхгүй	Жилд 3000 орчим хэмжих хэрэгслийг баталгаажуулна
3	Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид шалгалт, тохируулга хийхэд шаардлагатай эталон төхөөрөмжийг бий болгох	байхгүй	Жилд 2500 орчим хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалгалт, тохируулгад хамруулна
4	Нийслэл, бүсийн төвүүдэд шинээр байгуулагдах баталгаажуулалтын болон шалгалт, тохируулгын лабораторийн ажилтан, улсын шалгагч нарын сургалтын болон олгосон сертификатын тоо	байхгүй	Жилд 2 удаа сургалт зохион байгуулж, 15-20 хүнийг хамруулна. Олгох сертификатын тоо 30-40
5	Хэмжил зүйн олон улсын болон бүс нутгийн байгууллагын 2010-2013 оны сургалтад эмчилгээ, оношилгооны хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, засвар үйлчилгээ, баталгаажуулалтын чиглэлээр хамрагдсан хүний тоо	байхгүй	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо 10-15

6	Холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, хот, дүүргийн хэмжээнд эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх (угсрах), суурилуулах, засварлах ажлыг гүйцэтгэх байгууллагын тоо	байхгүй	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудын хүрээнд байгуулагдсан мэргэжлийн байгууллагын тоо 2-оос доошгүй байна
7	Эрүүл мэндийн салбарт хэрэглэх эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн загварыг туршилтад хамруулах хэмжих хэрэгслийн тоо	байхгүй	10-аас доошгүй загвар батлагдсан байна

Засгийн газрын 2009 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хэсэрт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, түүнд холбогдох арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран оролцох байгууллага	Хугацаа, оноор
Зорилт 1. Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийхэд шаардлагатай техникийн бааз суурийг бэхжүүлж бүрдүүлнэ				
1.1	Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн батлах, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хоорондын хугацааны норм, нормативыг шинэчлэх	СХЗГ	ЭМЯ	2011-2012

1.2	Хөтөлбөрийн хүрээнд бий болгох, шинээр худалдан авах агааланы жагсаалтыг гаргаж, агааланы худалдан авах тендерийн ажлыг зохион байгуулах.	СХЗГ	-	Жил бүр
1.3	Улаанбаатар, Ховд, Дархан, Чойбалсан, Эрдэнэт хотуудад эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийх зориулалтын лабораторийг нээн ажиллуулах	СХЗГ	-	2011
1.4	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын лабораторид ажиллах мэргэжилтний мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын сургалтад хамруулах, олон улсын байгууллага болон бүс нутгийн хэмжил зүй, эрүүл мэндийн байгууллагуудын талаархи шаврдлагатай мэдээллээр хангах, холбогдох мэргэжлийн их, дээд сургуультай хамтран ажиллах.	ЭМЯ	СХЗГ	Жил бүр
Зорилт 2. Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг олон улсын түвшинд судлан хөгжүүлэх, эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх арга зүй, стандартыг олон улсын түвшинд боловсруулах ажлыг зохион байгуулна				
2.1	Хөтөлбөрийн хүрээнд эрдэм шинжилгээний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг явуулах, оношилгоо, эмчилгээний үйл ажиллагаатай уялдуулах	СХЗГ	ЭМЯ	Жил бүр
2.2	Эмнэлгийн шинжилгээ, оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалтыг шалгах стандартыг олон улсын түвшинд боловсруулах ажлыг жил бүрийн стандартчилуулын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	СХЗГ	ЭМЯ	Жил бүр

2.3	Эрүүл мэндийн салбарт хэрэглэх эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн загварыг турших, батлах, мөрдөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж явуулах	СХЗГ	ЭМЯ	Жил бүр
Зорилт 3. Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа болон цаашид ашиглах оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг баталгаажуулалт, шалгалт, тохируулгад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна				
3.1	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, стандартчилсан загварыг улсын бүртгэлд хамруулах	СХЗГ	ЭМЯ	2010-2013
3.2	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, стандартчилсан загварын улсын бүртгэлийн журам боловсруулах	СХЗГ	ЭМЯ	Жил бүр
3.3	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг график, төлөвлөгөөний дагуу улсын бүртгэл, баталгаажуулалт, шалгалт, тохируулгад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулан гүйцэтгэх	СХЗГ ЭМЯ	-	Жил бүр
3.4	Эрүүл мэндийн салбарын оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэмжил зүйн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	МХЕГ	-	Жил бүр
Зорилт 4. Эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тасралтгүй хангахад чиглэсэн засвар, үйлчилгээний зохион байгуулалтын ажлыг дэмжин хөгжүүлнэ				
4.1	Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах, шалгалт, тохируулгыг хийж гүйцэтгэх байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах	СХЗГ	ЭМЯ	2011-2013



4.2	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засварын инженерийн мэргэшлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ЭМЯ	БСШУЯ	Жил бүр
	Зорилт 5. Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах, тэдгээрт баталгаажуулалт, шалгалт, тохируулга хийх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах тогтвортой, уян хатан тогтолцоог бүрдүүлж хөгжүүлнэ			
5.1	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бусад салбарын оролцоог идэвхжүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий салбар дундын техникийн зохицуулах хороог бий болгох	СХЗГ	ЭМЯ	2010-2011
5.2	Улсын хэмжээнд эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, шалгалт, тохируулгыг олон улсын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх	СХЗГ	-	Жил бүр
5.3	Импортоор орж ирж байгаа эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тусгай зөвшөөрлийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд болон бусад байгууллага, аж ахуйн байгууллага уян хатан бодлогоор зохицуулан шийдвэрлэх	СХЗГ	ЭМЯ	Жил бүр
5.4	Эрүүл мэндийн болон холбогдох байгууллагын жил бүрийн төсөвт эмнэлгийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, баталгаажуулалт, шалгалт, тохируулгын зардлыг тусгаж байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	СЯ	ЭМЯ	Жил бүр

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакция


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medelelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1.25

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгээс хэвлэв,
Утас 329487